



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2005 оны 12 сарын 08 өдөр


Дугаар 385

Гадаадад суралцуулах тухай

2004-2005 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2004 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэл, Англи улсын Лондон хотын Дипломатын академийн 2005 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2004 оны 225 дугаар тушаалын дагуу Англи улсын Лондон хотын Дипломатын академийн магистрантурт Гадаад хэргийн яамны захиалгаар суралцаж буй Доржсүрэн овогтой Ариунтуяагийн суралцах хугацааг хагас жилээр сунгасугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын газрын Мэргэжлийн боловсролын хэлтэс /Д.Баяр/-т тус тус даалгасугай.



САЙД

П.ЦАГААН